



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2020 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ГАА-СТА-2021/01/-ТЕЗ

Говь-Алтай аймаг 2021 он

Дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр

Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер Д.Эрдэнэчимэг

Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Цэрэнханд

Утас: 70484030 Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn

Аудитор Г.Энхдэлгэр

Утас: 70484030 Цахим хаяг: enkhdelgerg@audit.gov.mn

Аудитор Б.Цэвэлмаа

Утас: 70484030 Цахим хаяг: Tsevelmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөгөөр)	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан (мянган төгрөгөөр)	11
3. Аудитын тайлан	14
3.1. Ерөнхий зүйл	14
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	15
3.4 Материаллаг байдал	16
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	16
3.5.1 Мөнгөн хөрөнгө	16
3.5.2 Авлага	18
3.5.3 Бараа материал	19
3.5.4 Үндсэн хөрөнгө	21
3.5.5 Өр төлбөр	23
3.5.6 Засгийн газрын хувь оролцоо	23
3.5.7 Орлогын данс	23
3.5.8 Зардлын данс	24
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	25
3.7 Шилэн дансны мэдээлэл	27
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	28
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	29
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	32
1. Менежментийн захидал	
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	

Товчилсон үгийн жагсаалт

ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АТҮГ	Алтай хотын тохижилт үйлчилгээний газар
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
БХНСБХС	Байгаль хамгаалах нөхөн сэргээх барьцаа хөрөнгийн сан
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЖДҮХС	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МХС	Мал хамгаалах сан
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
НДШ	Нийгмийн даатгалын шийтгэл
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар
ОНТҮГ	Орон нутгийн төсөвт үйлдвэрийн газар
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
СХС	Сум хөгжүүлэх сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ХХААХҮ	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрлэл
ХХААЯ	Хүнс хөдөө аж ахуйн яам
ЭМТ	Эрүүл мэндийн төв

Дүрслэл, хүснэгтийн товчлол:

- Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл
- Хүснэгт №2: Төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл
- Хүснэгт №3: Авлага дансны үлдэгдэл
- Хүснэгт №4: Бараа материалын үлдэгдэл
- Хүснэгт №5: Урьдчилгаа дансны үлдэгдэл
- Хүснэгт №6: Үндсэн хөрөнгийн үлдэгдэл
- Хүснэгт № 7: Нийт өр төлбөрийн үлдэгдэл
- Хүснэгт № 8: Засгийн гарзын хувь оролцоо дансны үлдэгдэл
- Хүснэгт № 9 : Үр дүнгийн орлого
- Хүснэгт № 10: Үр дүнгийн зардал
- Хүснэгт № 11: Нэгтгэсэн тайлангийн 2020 оны төсвийн гүйцэтгэл /хураангуй/
- Хүснэгт №12: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шийдвэрийн төлбөрийн хэрэгжилт
- График 1: Нийт өр төлбөр
- График 2: Сумдын татварын орлого
- График:3: Нэмэлт санхүүжилтийн орлого, зарцуулалт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
О.АМГАЛАНБААТАР ТАНАА

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2021.04.20 № 199
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Төсвийн Ерөнхийлөн захирагч Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн 6 зорилтын хүрээнд тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг 90 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан		(мян.төгрөгөөр)	
Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	33,827,431.7	34,671,930.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	5,928,490.8	9,806,283.1
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.0	0.0
33	АВЛАГА	13,838,185.2	13,078,395.7
34	УРЬДЧИЛГАА	149,121.6	151,160.6
35	БАРАА МАТЕРИАЛ	7,249,824.4	8,118,712.0
36	НӨӨЦИЙН БАРАА	297,126.7	246,818.6
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	6,364,683.2	3,270,561.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	125,504,224.5	148,156,078.3
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.0	0.0
37100	Урт хугацаат хадгаламж	0.0	0.0
37200	Үнэт цаас	0.0	0.0
37300	Урт хугацаат зээл	0.0	0.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	125,504,224.5	148,156,078.3
39100	Газар	0.0	0.0
39200	Биет хөрөнгө	120,098,945.9	142,104,474.6
39300	Биет бус хөрөнгө	5,405,278.6	6,051,603.7
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	0.0	0.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	159,331,656.2	182,828,009.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	15,408,482.4	13,841,958.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,699,440.4	2,334,330.2
41100	Богино хугацаат үнэт цаас	0.0	0.0
41200	Богино хугацаат зээлийн өглөг	58,340.6	18,079.2
41300	Өглөг	1,451,326.5	959,477.2
41400	Урьдчилж орсон орлого	1,189,773.4	1,356,773.7
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	12,709,042.0	11,507,627.8
42100	Урт хугацаат үнэт цаас	0.0	0.0
42200	Урт хугацаат зээл	12,709,042.0	11,507,627.8
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	143,923,173.8	168,986,051.2
51	Засгийн газрын хувь оролцоо	143,923,173.8	168,986,051.2
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	54,206,989.9	54,504,139.4
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	1,084,560.6	5,337,744.2
51102	Өмч /хувийн/ /ТӨҮГ/	0.0	0.0
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	53,702.0	53,702.0
51200	Хуримтлагдсан үр дүн	47,921,377.9	68,468,087.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	40,656,543.4	40,622,378.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	159,331,656.2	182,828,009.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (мян.төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	166,943,799.6	102,932,463.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	7,628,220.9	8,372,178.5
110	Орлогын албан татвар	5,947,283.0	6,737,382.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	6,397,246.1	7,121,669.3
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-449,963.1	-384,287.0
113	Хөрөнгийн албан татвар	586,518.6	591,580.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,094,419.3	1,043,216.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	74,832,447.3	88,739,259.0
120	Нийтлэг татварын бус орлого	25,036,794.5	27,800,638.2
121	Хөрөнгийн орлого	200,446.1	29,780.9
122	Тусламжийн орлого	1,970.0	33,365.5
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	49,593,236.7	60,875,474.3
124	Зээлийн орлого	0.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	84,483,131.4	5,821,026.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	136,231,953.8	73,145,229.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	136,231,953.8	73,145,229.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	61,818,538.8	68,961,139.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	33,062,804.7	38,541,451.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,165,995.2	4,789,265.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,755,331.6	5,741,735.3
2104	Хангамж, бараа материалын зардал	1,971,406.3	1,972,171.4
2105	Нормативт зардал	1,961,792.2	2,201,981.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	887,384.7	447,294.2
2107	Томиллолт, зочны зардал	518,226.2	181,286.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,862,648.7	6,924,208.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,632,949.3	8,161,746.2
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	19,992.4	16,352.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	74,393,422.6	4,167,737.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	30,711,845.8	29,787,233.7
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.0	39,900.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	14,793,807.7	9,314,532.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	15,918,038.1	20,512,601.6

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (мян.төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	72,259,566.0	81,052,360.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	7,628,220.9	8,372,178.5
110	Орлогын албан татвар	5,947,283.0	6,737,382.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	6,397,246.1	7,121,669.3
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-449,963.1	-384,287.0
113	Хөрөнгийн албан татвар	586,518.6	591,580.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,094,419.3	1,043,216.1
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	394,161.5	342,790.7
1181	Газрын төлбөр	366,779.6	490,373.3
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	318,806.9	205,026.6
1183	Бусад татвар	14,671.3	5,025.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	54,563,623.3	66,884,467.4
120	Нийтлэг татварын бус орлого	4,769,740.5	5,979,212.2
121	Хөрөнгийн орлого	200,446.1	29,780.9
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	49,593,236.7	60,875,474.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,067,721.8	5,795,714.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	56,592,000.4	66,358,312.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	56,592,000.4	66,358,312.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	54,281,515.7	62,167,175.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	33,173,731.3	39,616,961.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,311,448.5	5,124,525.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,545,054.6	6,236,220.5
2104	Хангамж, бараа материалын зардал	2,403,271.3	2,818,149.2
2105	Нормативт зардал	1,982,111.1	1,993,747.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,091,469.5	567,858.2
2107	Томилолт, зочны зардал	516,396.0	180,372.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,725,163.0	4,200,467.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,532,870.4	1,428,872.6
212	ТАТААС	19,992.4	23,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,290,492.3	4,168,136.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	15,667,565.6	14,694,048.5
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	13,686.5	160,317.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	16,132,463.5	10,246,410.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,132,463.5	10,246,410.0
2200	Дотоод эх үүсвэрээр	16,132,463.5	10,246,410.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-16,118,776.9	-10,086,092.6
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	439,145.1	-730,163.6
14	Бусад эх үүсвэр	1,389,241.1	76,050.0

23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	886,549.9	742,350.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	63,546.1	63,863.6
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-12,066.2	3,877,792.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,940,557.0	5,928,490.8
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,928,490.8	9,806,283.1

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (мян.төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	128,143,974.5	128,143,974.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-4,798,383.1	-4,798,383.1
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	123,345,591.4	123,345,591.4
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	3,276,386.8	3,276,386.8
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	2,581.4	2,581.4
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчилөлт	1,380,576.0	1,380,576.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	15,918,038.1	15,918,038.1
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	143,923,173.8	143,923,173.8
11	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	143,923,173.8	143,923,173.8
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	19,710.2	19,710.2
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	143,942,884.1	143,942,884.1
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-28,120.9	-28,120.9
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	63,550.8	63,550.8
17	Өмчид гарсан өөрчилөлт	4,495,135.6	4,495,135.6
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	20,512,601.6	20,512,601.6
20	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	168,986,051.2	168,986,051.2

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (мян.төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант он	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл

1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	72,832,307.40	64,822,083.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	62,927,929.10	58,878,240.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	61,349,913.70	57,464,183.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	39,656,368.60	38,174,286.83
210101	Үндсэн цалин	32,084,250.90	30,870,921.53
210102	Нэмэгдэл	1,740,583.10	1,840,755.78
210103	Унаа хоолны хөнгөлөлт	332,000.60	288,754.87
210104	Урамшуулал	3,199,048.00	3,003,463.94
210105	Гэрээт ажлын хөлс	2,300,486.00	2,170,390.71
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,082,703.60	4,799,852.39
210201	Тэтгэврийн даатгал	3,752,324.60	3,544,291.04
210202	Тэтгэмжийн даатгал	161,468.80	157,697.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	314,184.80	301,003.17
210204	Ажилгүйдлийн даатгал	93,711.50	82,459.42
210205	Эрүүл мэндийн даатгал	761,013.90	714,401.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,550,782.90	6,027,045.71
210301	Гэрэл, цахилгаан	466,157.90	348,863.88
210302	Түлш, халаалт	5,858,719.20	5,504,807.54
210303	Цэвэр, бохир ус	225,905.80	173,374.29
210304	Байрны түрээс	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	1,648,390.20	1,575,099.11
210401	Бичиг хэрэг	200,912.50	196,329.47
210402	Тээвэр, шатахуун	971,562.80	929,344.61
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	137,399.70	127,123.87
210404	Ном, хэвлэл	38,278.00	35,858.39
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	58,715.60	53,969.94
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	241,521.60	232,472.83
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	-
2105	Нормативт зардал	2,500,834.00	1,680,647.37
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	155,441.70	137,471.85
210502	Хоол, хүнс	2,182,054.30	1,383,921.16
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	163,338.00	159,254.35
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,229,000.60	1,137,480.80
210601	Багаж, техник, хэрэгсэл	559,473.70	536,627.45
210602	Тавилга	87,372.00	72,728.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	18,615.00	16,162.00
210604	Урсгал засвар	563,539.90	511,963.35
2107	Томилолт, зочны зардал	220,826.40	149,198.50
210701	Гадаад албан томилолт	-	-
210702	Дотоод албан томилолт	220,826.40	149,198.50
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,898,892.00	2,429,348.89

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,750,987.30	2,298,053.34
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	52,963.00	47,059.30
210803	Даатгалын үйлчилгээ	23,187.50	22,404.86
210804	Тээврийн хэрэгслийн татвар	7,606.70	5,789.15
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	2,992.70	2,159.73
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	39,900.90	35,752.80
210807	Газрын төлбөр	5,052.90	3,404.14
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,641.00	4,995.37
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	10,560.00	9,730.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,562,115.40	1,491,224.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,423,736.70	1,363,750.79
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	138,378.70	127,473.61
212	ТАТААС	23,000.00	23,000.00
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	-
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	-
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	23,000.00	23,000.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	23,000.00	23,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,555,015.40	1,391,056.94
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	331,587.90	319,301.80
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	331,587.90	319,301.80
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,223,427.50	1,071,755.14
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	-
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	105,000.00	71,597.50
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	141,509.10	141,509.10
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	370,273.70	301,892.65
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	-	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	293,406.00	262,660.40
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	313,238.70	294,095.49
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,363,241.70	5,201,492.07
2200	Дотоод эх үүсвэрээр	8,363,241.70	5,201,492.07
223001	Бусад хөрөнгө	8,363,241.70	5,201,492.07
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,541,136.60	742,350.00
230001	Эргэж төлөгдөх зээл	1,541,136.60	742,350.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	72,832,307.40	67,834,233.48
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	38,591,294.80	36,190,775.88
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	38,591,294.80	36,190,775.88
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	31,684,742.40	29,922,824.91
132001	Орон нутгийн төсвөөс	24,115,087.10	22,543,364.57
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	7,569,655.30	7,379,460.34
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН	320,583.20	180,759.80

ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ			
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	320,583.20	180,759.80
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	-	-
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,235,687.00	1,539,872.90
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,011,618.70	1,136,257.48
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	155,188.00	403,615.41
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,068,880.30	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,485,140.55
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	4,484,746.46
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	6,764	6,690
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	142	142
610001	Төсвийн байгууллага	141	141
610002	Төсвөөс гадуур байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	3,311	3,274
620001	Удирдах ажилтан	279	270
620002	Гүйцэтгэх ажилтан	1,903	1,887
620003	Үйлчлэх ажилтан	725	722
620004	Гэрээт ажилтан	404	395
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	3,311	3,274
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	386	379
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	-	-
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	-	-
650004	ССБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	1,203	1,202
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	22	22
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	168	156
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	-	-
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	246	245
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	972	971
650010	Гэрээт ажилтан	167	159
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	147	140

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (мян.төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,385,154.67	3,587,126.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,234,554.67	3,429,126.09

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,851,221.10	2,458,488.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	96,085.38	94,098.15
210101	Үндсэн цалин	65,772.12	47,331.06
210102	Нэмэгдэл	2,800.00	1,060.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	156.00
210104	Урамшуулал	3,640.00	8,851.83
210105	Гэрээт ажлын хөлс	23,873.26	36,699.27
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,854.34	6,580.32
210201	Тэтгэврийн даатгал	8,854.34	6,580.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,065.00	3,604.50
210301	Гэрэл, цахилгаан	885.00	963.90
210302	Түлш, халаалт	180.00	2,640.60
2104	Хангамж, бараа материалын зардал	115,043.25	151,522.38
210401	Бичиг хэрэг	21,849.20	7,724.47
210402	Тээвэр, шатахуун	55,814.40	117,927.12
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	194.90	928.59
210404	Ном, хэвлэл	26,813.35	8,776.35
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,630.00	885.05
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,741.40	15,280.80
2105	Нормативт зардал	13,028.20	103,721.78
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,331.60	77,366.10
210502	Хоол, хүнс	5,416.50	19,800.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,280.10	6,555.08
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	685,396.59	193,850.71
210601	Багаж, техник, хэрэгсэл	426,970.33	138,738.70
210602	Тавилга	37,897.15	24,401.39
210604	Урсгал засвар	220,409.12	30,710.62
2107	Томилолт, зочны зардал	60,785.50	30,260.52
210702	Дотоод албан томилолт	58,485.50	30,260.52
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,340,288.75	1,645,555.73
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,338,961.55	1,645,555.73
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	530,674.10	229,294.71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	391,048.93	199,048.01
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	139,625.17	30,246.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,383,333.56	970,637.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	928,795.38	740,398.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	909,568.68	705,685.57
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,226.70	34,712.43
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	454,538.18	230,239.30
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	353.05
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн	454,538.18	229,886.25

	захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	150,600.00	158,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	150,600.00	158,000.00
223001	Бусад хөрөнгө	120,600.00	158,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,385,154.67	3,587,126.09
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,385,154.67	3,587,126.09
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	822,925.80	937,233.18
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	753,111.08	302,753.42
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,633,530.91	1,980,230.07
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	175,586.87	366,909.42

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төсвийн ерөнхийлөн захирагч О.Амгаланбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 04 дүгээр сарын 02-ний өдрөөс 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэнханд, аудитор Г.Энхдэлгэр, Б.Цэвэлмаа нар гүйцэтгэв.

Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төрийн аудитын газарт 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 01/418 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд аймгийн Засаг даргын бүрэн эрхийг тодорхойлсон.

Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг баталсан байна. Дараах зорилтын хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон байна. Үүнд:

- Ковид-19” цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогыг хэрэгжүүлнэ.
- Амьдралын хэв маягаас үүдэлтэй өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлж, хүний хөгжлийг дэмжинэ.
- Төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, үр ашгийг нэмэгдүүлнэ.
- Төрийн үйлчилгээг цахим болгон, авлига, ашиг сонирхлын зөрчил, гэмт хэрэг, болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх, батлан хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж, иргэний оролцоотой, нээлттэй, ил тод, хариуцлагатай засаглалын бодлого хэрэгжүүлнэ.
- Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Аймгийн төв болон сумдад цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэн, өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг дотоодоос бүрэн хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

Тайлант хугацаанд үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоол “Хоолны зардлын норматив тогтоох тухай”
- Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 “Жишиг норм тогтоох тухай”
- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан төрийн албан хаагчдад олгох, ур чадварын нэмэгдэл олгох журам
- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”
- Нийгмийн даатгалын тухай хуулиар нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ
- Бусад хууль тогтоомж

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын алба нь 2020 онд аймгийн төвийн болон сумдын нийт 67 байгууллага, тусгай зориулалтын сангийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийхээр төлөвлөж хэрэгжилтийг ханган ажилласан ба 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналтыг 2021 онд хийхээр төлөвлөсөн байна.

Сангийн яам, ХХААХҮ-ийн яам болон иргэдээс аймгийн Засаг дарга, тус албанд хандсан өргөдөл, хүсэлт, гомдлын дагуу төлөвлөгөөт бусаар “Мал эмнэлгийн газар”, “ТЭДС”, “ХХААГ”, “Гамшгаас хамгаалах сан”, “Худалдан авах ажиллагаа” /2017-2020 он/, Шарга сумын ОНХС-гийн хөрөнгөөр худгийн мотор нийлүүлсэн зэрэг асуудалд санхүүгийн хяналтыг хийсэн байна.

Тайлант онд “Солонго Дулааны станц” ААТҮГ, “Нийтийн номын сан”, “Биеийн тамир спортын газар”-ын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийн, аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан ажлын хэсгийн тайланд нэгтгүүлсэн байна. Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах, цаашид давтан гаргахгүй байх талаар холбогдох албан тушаалтнуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хүргүүлсэн үүргийн биелэлтийг тооцон ажилласнаас гадна системийн хэмжээнд хийгдэж байгаа шалгалтын материалыг Аудитын хороогоор хэлэлцүүлэн, удирдамжид заасан хугацаанд нь Сангийн яаманд цахимаар болон шуудангаар хүргүүлжээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад харьяалагдах 178 байгууллагын Шилэн дансны цэс хөтлөлт “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтэд хяналт хийхэд 2020 оны 03 дугаар улирлын байдлаар 96.6 хувьтай гэж дүгнэжээ. Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад 2020 оны жилийн эцсийн байдлаар 90.0 хувьтай байна.

Дотоод хяналт шалгалтыг эрсдэлтэй асуудлыг хамруулан гүйцэтгэх шаардлагатай байгаа нь Төрийн аудитын газраас 2020 оны санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтээс /Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, цалин, нэмэгдлийг зөрүүтэй тооцож олгосон, холбогдох хууль журмыг зөрчсөн, төсвийг зохистой удирдаагүйгээс өр төлбөр, авлага үүсгэсэн гэх мэт/ харагдаж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад үе шатны хяналтыг сайжруулах шаардлагатай байна. Тухайлбал: Шүүхийн шийдвэрээр олгосон цалингийн нөхөн олговор 256.8 сая төгрөгийг барагдуулах, сангуудаас олгосон зээлийн эргэн төлөлт, зориулалт гэх мэт Төрийн аудитын байгууллагаас гаргасан шийдвэрт үндэслэн эрсдэлтэй асуудалд анхаарлаа хандуулах шаардлагатай.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал болох 74,369.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 1,487.4 сая төгрөгөөр тооцсон. Гүйцэтгэлийн шатанд 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал болох 82,459.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 1,649.2 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

3.5 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 5,928.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 9,806.3 сая төгрөг болж, 3,877.8 сая төгрөгөөр өссөн байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос өссөн нь орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл 1,676.8 сая төгрөг, төсөвт байгууллагын харилцахын үлдэгдэл 59.9 сая төгрөг, төсөл сангуудын үлдэгдэл 2,904.2 сая төгрөгөөр тус тус өссөн, ОНӨААТҮГ-уудын үлдэгдэл 763.3 сая төгрөгөөр буурсантай холбоотой.

Жилийн эцсийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 95.0 хувь буюу 9,319.7 сая төгрөг нь төрийн сангийн харилцах дансанд, 5.0 хувь буюу 486.1 сая төгрөг нь арилжааны банк дахь харилцах дансанд, 0.005 хувь буюу 0.484 сая төгрөг нь байгууллагуудын кассын дансанд байршиж байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	4.16	0.48	(3.67)
Төрийн сангийн харилцахад байгаа мөнгө	4,738.68	9,319.68	4,581.01
Банканд байгаа бэлэн мөнгө	1,185.66	486.11	(699.54)
Дүн	5,928.49	9,806.28	3,877.79
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр харуулбал</i>			
Сумын орлогын дансны үлдэгдэл	966.69	1,979.22	1,012.53
Аймгийн Ерөнхий орлогын үлдэгдэл	1,275.71	1,940.01	664.30
Төсөвт байгууллага	6.04	21.59	15.54
Төсөл сан	2,496.28	5,400.47	2,904.19
ТӨҮГ болон ОНӨААТҮГ	1,183.77	464.99	(718.78)
Дүн	5,928.49	9,806.28	3,877.79

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төрийн сангийн харилцах дансанд байршиж байгаа 9,806.3 сая төгрөгөөс 1,979.2 сая төгрөг нь сумын орон нутгийн орлогын дансанд, 1,940.01 сая төгрөг нь аймгийн Ерөнхий орлогын дансанд, 65.8 сая төгрөг нь төсөвт байгууллагын дансанд, 5,400.5 сая

төгрөг нь төсөл сангийн дансанд, 420.75 сая төгрөг нь ОНӨААТҮГ-ын дансанд тус тус байна.

Жилийн эцсийн кассын дансны үлдэгдэл нийт 0.484 сая төгрөг байгаагаас 89.6 хувь буюу 0.4 сая төгрөг нь “Алтай орон сууцны корпораци” ОНӨААТҮГ-ын үлдэгдэл, 7.7 хувь буюу 0.03 сая төгрөг нь “ Ундарга-Алтай” ОНӨУГ-ын үлдэгдэл, 2.5 хувь буюу 0.01 сая төгрөг нь “Солонго Дулааны станц” ААТҮГ-ын үлдэгдэл байна.

Аймаг, сумдын орон нутгийн орлогын мөнгөн хөрөнгө

Аймаг, сумдын орлогын дансны мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 2,242.4 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 3,919.2 сая төгрөг болж, 1,676.8 сая төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахал гарснаас Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын тогтмол зардал хэмнэгдэн, буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгө

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 6.0 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 21.6 сая төгрөг болж, 15.5 сая төгрөгөөр өссөн байна.

Төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгө 15.5 сая төгрөгөөр өссөн нь Ахмадын хороо 5.1 сая, аймгийн ЗДТГ 3.1 сая, “Энх-Алтай” ӨЭМТ 4.9 сая, Дэлгэр сумын ЕБС 2.5 сая төгрөгөөр тус тус хэмнэгдэн мөнгөн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

➤ Төсөл сангийн мөнгөн хөрөнгө

Төсөл сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 2,496.3 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 5,400.5 сая төгрөг болж, 2,904.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Ковид-19 цар тахал гарснаас ОНХС-гийн хөрөнгөөр хийхээр төлөвлөсөн ажил хийгдээгүйтэй холбоотой байна.

Хүснэгт №2: Төсөвт байгууллагын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Банк дахь байгаа бэлэн мөнгө	
			Арилжааны банк	Төрийн сангийн харилцах
ОНХС	317.03	2,942.75		2,942.75
СХС	924.81	1,165.16		1,165.16
БХНСС	184.94	182.93		182.93
МХС	173.86	219.71		219.71
ТЭДС	55.95	39.40		39.40
Халамжийн сан	0.00	0.02	0.02	
Аймгийн ОНХС	13.43	107.25		107.25
Хөрөнгө оруулалт	826.26	743.24		743.24
дүн	2,496.28	5,400.47	0.02	5,400.45

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

➤ ТӨҮГ болон ОНӨААТҮГ-ын мөнгөн хөрөнгө

Тайлант онд ОНӨААТҮГ-уудын мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 1,183.7 сая төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 464.9 сая төгрөг болж 718.8 сая төгрөгөөр буурсан нь “Алтай орон сууцны корпораци” ААТҮГ-ын дансанд үлдэгдэлтэй байсан орон сууцны төлбөрийг Хөгжлийн банкинд төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Өмнөх оны аудитаар мөнгөн хөрөнгийн зарцуулалттай холбоотой 2,929.1 сая төгрөгийн зөрчил илэрч аудитын явцад 1,395.1 сая төгрөгийн алдааг залруулж байсан бол тайлант онд 6,632.2 сая төгрөгийн зөрчил илэрч аудитын явцад 3,664.7 сая төгрөгийн алдааг залруулж зөрчил 226 хувиар өссөн үзүүлэлттэй байна. /Хавсралт №1, 2, 3-д дэлгэрэнгүй харуулав./

Дараах нийтлэг зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Цалин хөлс нэмэгдэл олгохтой холбогдсон нийт 341.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:

➤ Орон тоо илүү ажиллуулсан, төсөвт батлагдаагүй 140.2 сая төгрөгийн цалин олгосон-14 байгууллага,

- Цалингийн зардлаас ангилал зөрчиж 43.0 сая төгрөгийн зарлага гаргасан-14 байгууллага, цалингийн нэмэгдлийг илүү дутуу тооцож олгосон, давхардсан 60.8 сая төгрөг /ихэнх байгууллагууд/
- Сахилгын шийтгэлтэй ажилтанд 3.7 сая төгрөгийн урамшуулал олгосон-7 байгууллага, тушаал шийдвэргүй 19.9 сая төгрөгийн урамшуулал, нэмэгдэл олгосон-4 байгууллага,
- Цалинг сүлжээ шатлалаас дээгүүр цалинжуулсан-2 байгууллага байна.
- 2. Шатахуун шууд зардлаар тайлагнасан, анхан шатны баримтгүй, тооцооны хуудас үндэслээгүй, зориулалт бусаар зарцуулсан нийт 201.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:
 - Няравын тайланд орлого аваагүй шууд зарлагадсан 102.3 сая төгрөг-8 байгууллага
 - Шатахууны тооцоо бодоогүй 12.3 сая төгрөг-4 байгууллага
 - Анхан шатны баримтгүй /замын хуудасгүй/ 73.7 сая төгрөг-16 байгууллага
 - Зориулалт бус, үр ашиггүй зарцуулсан 4.5 сая төгрөг-13 байгууллага
 - Спидометрийн заалтгүй, заалт зөрүүтэй 8.6 сая төгрөг-6 байгууллага байна.
- 3. Халаалт, ус, цахилгааны зардлын зарцуулалтыг нормоос илүү хэмжээгээр зарцуулсан, үр ашиггүй, анхан шатны баримтгүйгээр зарцуулсан 17.3 сая төгрөг-4 байгууллага байна.
- 4. Хоолны зардалтай холбоотой 15.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:
 - Нормативаас илүү, зориулалт бусаар зарцуулсан 2.1 сая төгрөг- 5 байгууллага
 - Анхан шатны баримтгүй зарлагадсан 12.5 сая төгрөг-2 байгууллага
 - Хүүхдэд хүнсний дэмжлэгийг илүү олгосон 0.6 сая төгрөг-2 байгууллага
- 5. Эм боох материалтай холбоотой 5.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн-6 байгууллага
- 6. Бараа ажил үйлчилгээний зардалтай холбоотой 81.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн-3 байгууллага
- 7. ЗДНХ-ээс зориулалт бусаар зарцуулсан 59.6 сая төгрөг зөрчил илэрсэн -3 байгууллага
- 8. Бусад /зардлын зүйл анги зөрчсөн, и баримтгүй гүйлгээ хийсэн, анхан шатны баримтгүй, кассын ажиллагааны журам зөрчсөн, төлөөлөгчдөд урамшуулал олгосон, төсвөөс акт төлбөр төлсөн, хандив өгсөн, шууд захирагч өөрөө өөртөө тушаал гарган урамшуулал, шагнал авсан, төрийн сангийн гарын үсэг тэмдэггүй гүйлгээ хийсэн, хамаарал бүхий этгээдээс худалдан авалт хийсэн, хэмнэлтийг төвлөрүүлээгүй ААТҮГ-т шилжүүлэн авлага, өглөг үүсгэсэн, анхан шатны баримтыг зассан гэх мэт/ 2,309.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 13,435.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 13,078.4 сая төгрөг болж, 357.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Авлага дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая.төгрөг/ Өсөлт+, бууралт-
Ажиллагчидтай холбогдсон авлага	47.8	55.2	7.4
Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-	-
Татаас, санхүүжилтийн авлага	-	-	-
Зээлийн хүүгийн авлага	190.6	174.6	(16.0)
Дансны авлага /ТӨҮГ/	6,858.4	6,515.9	(342.5)
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	1.2	0.5	(0.7)
Бусад авлага	2,330.0	2,584.0	254.0
Зээлийн авлага	4,007.7	3,748.2	(259.5)
дүн	13,435.7	13,078.4	(357.3)
Үүнээс байгууллагын төрлөөр	-	-	-
Төсөвт байгууллага	745.7	616.6	(129.1)
Төсөл/сан	5,089.1	4,831.4	(257.7)
Төрийн сан	669.6	564.1	(105.5)
ТӨҮГ болон ОНӨҮГ	6,931.4	7,066.4	135.0
дүн	13,435.7	13,078.4	(357.3)

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдлийн 16.8 хувь буюу 2,199.5 сая төгрөгийг орон нутгийн төсвийн байгууллага, 0.5 хувь буюу 63.2 сая төгрөгийг ЕБС, 0.2 хувь буюу 30.48 сая төгрөгийг Хүүхдийн цэцэрлэг, 0.2 хувь буюу 25.6 сая төгрөгийг ЭМТ, 26.2 хувь буюу 3,432.0 сая төгрөгийг СХС, 2 хувь буюу 265.0 сая төгрөгийг ТЭДС, МХС, 54.0 хувь буюу 7,062.2 сая төгрөгийг ОНӨААТҮГ-ын авлагууд тус тус эзэлж байна.

ОНӨААТҮГ-ын авлага өндөр байгаа нь “Алтай орон сууцны корпораци” ААТҮГ-т бүртгэлтэй Төрийн орон сууц корпорацийн санхүүжилтээр баригдсан 120 айлын орон сууцыг иргэдэд зээлийн 6,670.3 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаатай холбоотой байна.

Шүүхийн шийдвэрээр олгосон цалингийн нөхөн олговрын авлагын эхний үлдэгдэл 287.0 сая төгрөг, тайлант онд 56.6 сая төгрөгийг нэмж төсвөөс олгон, 2.9 сая төгрөгийг буруутай этгээд төлж барагдуулан, 61.3 сая төгрөгийн авлагыг Шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болгож, эцсийн үлдэгдэл 279.5 сая төгрөг байна.

Өмнөх оны Шүүхийн шийдвэрээр олгосон цалингийн авлага 222,819.3 сая төгрөгийг барагдуулахаар ямар нэгэн арга хэмжээ авч ажиллаагүй ба уг зөрчлийг арилгуулахаар жил бүр албан шаардлага хүргүүлж байгаа боловч хэрэгжилт хангалтгүй байна.

Олон жилийн насжилттай 1,167.0 сая төгрөгийн авлагаас 21.2 хувь буюу 248.5 сая төгрөгийг төсөвт байгууллагуудын авлага, 78.7 хувь буюу 918.5 сая төгрөгийг сангуудын авлага эзэлж байна. Тухайлбал: Төсөвт болон ААТҮГ-ын дараах авлагууд байна.

- Алтай сумын ЗДТГ-ын 40.0 сая төгрөг –“Бүрдмэл Алтай” ХХК-иас авах авлага
- Халиун сумын ЗДТГ-ын 16.0 сая төгрөг- “Эв Алтай” ХХК-иас авах авлага
- Биеийн тамир спортын газрын 35.0 сая төгрөг- “Их Цэнхэр” ХХК-иас авах авлага
- Эрүүл ус ОНӨААТҮГ-ын 97.8 сая төгрөг- Хувь хүн, ААНБ-тай холбоотой
- Нийтлэг үйлчилгээ” ОНТҮГ-ын 25.4 сая төгрөг- Хувь хүн, ААНБ-тай холбоотой авлагууд байна. /Хавсралт № 4а-д дэлгэрэнгүй харуулав./

Эзэн холбогдогчид нь нас барсан, оршин суугаа хаяг тодорхойгүйгээс шүүхэд хандах боломжгүй, хөөн хэлэлцэх хугацаа дууссанаас шүүхээр шийдвэрлүүлэх боломжгүй болсон найдваргүй 5.0 сая төгрөгийн авлага байна. Үүнд:

- Бигэр сумын ЕБС-ын авлага 0.9 сая төгрөг
- Дэлгэр сумын ЗДТГ-ын авлага 4.2 сая төгрөг тус тус байна.

Аудитын илрүүлэлт: Өмнөх оны аудитаар авлагатай холбоотой нийт 2,719.5 сая төгрөгийн зөрчил илэрч аудитын явцад 1,501.1 сая төгрөгийн алдааг залруулж байсан бол тайлант онд 3,872.7 сая төгрөгийн зөрчил илэрч, 730.5 сая төгрөгийн алдааг залруулж зөрчил 26 хувиар өссөн байна. /Хавсралт № 4б,5 -д дэлгэрэнгүй харуулав./

1. Төсөвт байгууллагын авлагатай холбоотой 370.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:
 - Тайлант онд Шүүхийн шийдвэрээр цалингийн нөхөн олговор олгож төсөв хохироосон 74.2 сая төгрөг- 8 байгууллага
 - Он дамнасан авлагыг барагдуулаагүй 169.4 сая төгрөг- 15 байгууллага
 - Авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 31.4 сая төгрөг-4 байгууллага
 - Тайлант онд их хэмжээний авлага үүсгэн өр төлбөртэй тайлагнасан 94.9 сая төгрөг-3 байгууллага
2. Төсөл, сан, ААТҮГ-ийн зээлийн эргэн төлөлттэй холбоотой 2,771.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Тухайлбал:
 - Гэрээт хугацаанд Сум хөгжүүлэх сангаас зээл авсан иргэдээр үндсэн зээл, хүүг төлүүлээгүй 404.7 сая төгрөг
 - Гэрээний дагуу үндсэн зээлээ төлөөгүй иргэдэд нэмж 9.9 сая төгрөгийн нэмэгдүүлсэн хүү, торгууль ногдуулсан
 - Зээлийн гэрээний хугацаа дууссан зээлдэгчдээс зээлийг Шүүхэд хандаж шийдвэр гаргуулаагүй 682.5 сая төгрөгийн зөрчил
 - Шүүхэд хандсан боловч эвлэрлийн гэрээний хугацаа дууссан зээлдэгчийн авлага 286.0 сая төгрөгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай гэрээ байгуулан барагдуулах арга хэмжээ аваагүй.
 - Хөгжлийн банкинд хүүгийн төлбөрийг төсвөөс төлсөн 459.4 сая төгрөг
 - Бусад 929.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /Гэрээний хугацаа дууссан байхад төлбөрийг төлүүлээгүй, орон сууц түрээслэх гэрээнд өөрчлөлт оруулаагүй, НД, Халамжийн сангийн тэтгэмжийг давхардуулан олгосон гэх мэт/

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансанд тайлант онд 151.1 сая төгрөг бүртгэгдэж өмнөх оноос 2.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	149.0	149.0	0
Цалингийн урьдчилгаа	0.1	2.1	2.0
Дүн	149.1	151.1	2.0
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	0.1	2.1	2.0
ОНӨААТҮГ	149.0	149.0	0
Дүн	149.1	151.1	2.0

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд 2019 онд үүссэн “Солонго дулааны станц” ААТҮГ-ын дулааны шугам сүлжээ хийхэд гарсан зардал, тайлант онд аймгийн ЗДТГ-т 2.1 сая төгрөгийн цалингийн урьдчилгаа бүртгэгдсэн байна.

“Солонго дулааны станц” ААТҮГ-ын дулааны шугам сүлжээний ажлыг улсын комисс хүлээн аваагүй байгаа тул зардлаар хүлээн зөвшөөрөөгүй хэвээр байна.

Аудитын илрүүлэлт: Тайлант онд урьдчилгаа олгоод суутгаагүй 5.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн – 9 байгууллага байна. /Хавсралт № 1-д дэлгэрэнгүй харуулав./

3.5.4 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 13,911.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 11,636.1 сая төгрөг болж, 2,275.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая.төгрөг/ Өсөлт бууралт
Түүхий эд материал	996.50	1,333.56	337.06
Хангамжийн материал	4,061.71	4,577.37	515.66
Нөөцийн бараа	6,661.81	3,517.38	(3,144.43)
дүн	13,911.63	11,636.09	(2,275.54)
Үүнээс байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага	6,927.17	7,813.15	885.99
Төсөл/сан	6,338.88	3,245.88	(3,093.00)
Төрийн сан	-	-	-
ТӨҮГ болон ОНӨҮГ	645.59	577.06	(68.53)
дүн	13,911.63	11,636.09	(2,275.54)

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны үлдэгдэл 2,275.5 сая төгрөгөөр буурсан нь ОНХС, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 3,107.9 сая төгрөгийн төсөл арга хэмжээг улсын комисс хүлээн авснаар борлуулах зорилгоор эзэмшиж байгаа бусад эргэлтийн хөрөнгө данс буурсантай холбоотой байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 6,132.8 сая төгрөгийн, хандиваар 564.1 сая төгрөгийн, дотооддоо 77.9 сая төгрөгийн, бүтцийн өөрчлөлтөөр 33.7 сая төгрөгийн бараа материал тус тус шилжүүлэн авч, бусад эх үүсвэрээс 669.1 сая төгрөгийн бараа материал хүлээн авч нийт 7,477.7 сая төгрөгийн бараа материал нэмэгдсэн байна.

Тайлант онд бараа материалаас 6,165.2 сая төгрөгийг зарцуулж, 3,139.2 сая төгрөгийг дотооддоо, 34.8 сая төгрөгийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн, 414.0 сая төгрөгийг акталж устган нийт 9,753.3 сая төгрөгийн бараа материал хасагдаж, үлдэгдэл 11,636.1 сая төгрөг байна.

Аудитын илрүүлэлт: Өмнөх оны аудитаар бараа материалын данстай холбоотой 1,696.0 сая төгрөгийн зөрчил илэрч аудитын явцад 156.4 сая төгрөгийн алдааг залруулж байсан бол тайлант онд 1,857.3 сая төгрөгийн зөрчил илэрч, аудитын явцад 477.8 сая төгрөгийн алдааг залуулж зөрчил 25 хувиар буурсан байна. /Хавсралт №7-д дэлгэрэнгүй харуулав./

Залруулагдаагүй дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Жилийн төсөв 10.0 сая төгрөгөөс хэтэрсэн шатахуун, хоол, нормын хувцас, бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтад худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй 726.8 сая төгрөг - 22 байгууллага
- Тендерт шалгараагүй ААНБ-аас худалдан авалт хийсэн 228.9 сая төгрөг -19 байгууллага
- Хөрөнгийн тооллого хийгдээгүй, тооллогын дүн НББ-ийн дүнгээс зөрүүтэй 124.3 сая төгрөг- 7 байгууллага
- ЗДТГ-ын данс бүртгэлд байгаа малыг олгоходоо гэрээ байгуулаагүй 124.5 сая төгрөг-6 байгууллага
- ЗДТГ-ын данс бүртгэлд байгаа малын гэрээний хугацаа дууссан байхад малыг дараагийн өрхөд шилжүүлээгүй 97.6 сая төгрөг - 6 байгууллага
- ЗДТГ-ын данс бүртгэлд байгаа малын гэрээний хугацаа дууссан байхад төлүүлээгүй 16.7 сая төгрөг-3 байгууллага
- ЗДТГ-ын данс бүртгэлд байгаа мал дутагдсан 21.4 сая төгрөг-4 байгууллага
- Биет тооллогоор бараа материал дутагдсан 6.1 сая төгрөг-3 байгууллага
- Бусад /шийдвэргүйгээр бараа материал акталсан, нярвын тайлан зөрүүтэй, бараа материал бодитоор ирээгүй байхад ирснээр тоолж бүртгэлд тусгасан/ 32.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 125,504.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 148,156.1 сая төгрөг болж 22,651.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	158,388.6	182,637.5	24,248.8
Хуримтлагдсан элэгдэл	38,287.9	40,533.0	2,245.1
Биет бус хөрөнгө	5,662.9	6,335.2	672.3
Хуримтлагдсан элэгдэл	259.3	283.6	24.2
Дүн	125,504.2	148,156.1	22,651.9
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	138,926.1	156,384.0	17,457.9
Төсөвт байгууллагын хуримтлагдсан элэгдэл	30,837.9	32,012.8	1,174.9
ОНӨААТҮГ-ууд	25,125.4	32,588.6	7,463.2
ОНӨААТҮГ-уудын хуримтлагдсан элэгдэл	7,709.3	8,803.7	1,094.4
Дүн	125,504.2	148,156.1	22,651.9

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт хөрөнгийн 96 хувийг биет хөрөнгө, 4 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 1,039.8 сая төгрөгийн, хандив тусламжаар 4,260.6 сая төгрөгийн, дотооддоо 5,399.2 сая төгрөгийн, бүтцийн өөрчлөлтөөр 11,783.6 сая төгрөгийн, бусад эх үүсвэрээс 21,409.7 сая төгрөгийн, дахин үнэлгээний нэмэгдлээр 85.3 сая төгрөгийн, нийт 43,978.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн.

Үндсэн хөрөнгө данснаас 41.9 сая төгрөгийн хөрөнгийг худалдан борлуулж, 1,629.5 сая төгрөгийн хөрөнгийг акталж устган, дотооддоо 583.1 сая төгрөгийн, бүтцийн өөрчлөлтөөр 11,761.8 сая төгрөгийн хөрөнгийг тус тус шилжүүлэн, бусад эх үүсвэрээс 4,982.3 сая төгрөгийн, дахин үнэлгээний хорогдлоор 58.3 сая төгрөгийн, нийт 19,057.2 сая төгрөгийн хөрөнгө хасагдаж, эцсийн үлдэгдэл 188,972.7 сая төгрөг байна. Үүнээс хуримтлагдсан элэгдэл 40.8 сая төгрөг, үлдэгдэл өртөг 148,156.1 сая төгрөг байна.

Алтай хотын тохижилт үйлчилгээний газрыг аймгийн ИТХ-ын тогтоолоор “Алтай хотын тохижилт үйлчилгээний газар” ААТҮГ болгон өөрчилснөөр тус газрын хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн бүртгэсэн байна.

Дуусаагүй барилга дансанд Есөнбулаг сумын 3 дугаар сургуулийн гадна спортын талбай 2012 оноос хойш бүртгэлтэй байна. Уг асуудалд ТШЗ-аар шийдвэр хүргүүлсэн болно.

Аудитын илрүүлэлт: Өмнөх оны аудитаар үндсэн хөрөнгөтэй холбоотой нийт 2,730.7 сая төгрөгийн зөрчил илэрч аудитын явцад 2,265.0 сая төгрөгийн алдааг залруулж байсан бол тайлант онд 383.1 сая төгрөгийн зөрчил илэрч, аудитын явцад 185.4 сая төгрөгийн алдааг залруулж зөрчил 86 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Залруулагдаагүй дараах зөрчлүүд байна. /хавсралт № 8-д дэлгэрэнгүй харуулав./

- Үлдэх өртөггүй хөрөнгөнд дахин үнэлгээ хийгээгүй 24.2 сая төгрөг-2 байгууллага
- Бараа материалын дансанд бүртгэсэн 15.9 сая төгрөг-1 байгууллага
- Биет тооллогоор хөрөнгө дутагдсан 13.4 сая төгрөг-1 байгууллага
- Бодитоор ирээгүй хөрөнгийг ирснээр тоолж бүртгэлд тусгасан 21.3 сая төгрөг-3 байгууллага
- Шилжиж ирсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй 1.0 сая төгрөг-1 байгууллага
- Тушаал шийдвэргүй хөрөнгө акталсан 0.4 сая төгрөг-1 байгууллага

3.5.6 Нийт өр төлбөр

Тайлант онд нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 15,005.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 13,841.9 сая төгрөг болж, 1,164.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 7: Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая.төгрөг/ Өсөлт+, бууралт-
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН	2,296.94	2,334.33	37.39
Богино хугацаат зээлийн өглөг	58.34	18.08	(40.26)
Өглөг	1,048.83	959.48	(89.35)
Урьдчилж орсон орлого	1,189.77	1,356.77	167.00
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН	12,709.04	11,507.63	(1,201.41)
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	15,005.98	13,841.96	(1,164.02)
Үүнээс байгууллагын төрлөөр	-	-	-
Төсөвт байгууллага	275.92	39.43	(236.49)
Төсөл/сан	1,317.00	1,229.89	(87.11)
Төрийн сан	-	2.00	2.00
ТӨҮГ болон ОНӨҮГ	13,413.06	12,570.63	(842.43)
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	15,005.98	13,841.96	(1,164.02)

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд МОН-2301, МОН-1847 төслийн хүрээнд хийгдсэн хөрөнгө оруулалттай холбоотой “Ундарга-Алтай” ОНӨААТҮГ-ын 4,711.4 сая төгрөгийн зээл, “Солонго дулааны станц” ААТҮГ-ын 115.6 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл, “Алтай орон сууцны корпораци” ААТҮГ-ын 6,680.6 сая төгрөгийн нийт 11,507.6 сая төгрөгийн зээл байна.

Нийт өр төлбөрийн 83 хувийг урт хугацаат өр төлбөр, 17 хувийг богино хугацаат өр төлбөр эзэлж байна.

Нийт өр төлбөр 1,164.02 сая төгрөгөөр буурсан нь дараах шалтгаантай.

- Дарив сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн данснаас ОНХС-гийн жишиг гудамж гүйцэтгэх 25.0 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулсан.
- “Ардын дуу бүжгийн Алтай” чуулгын халаалтын өглөгийг төлж барагдуулсан.
- “Алтай орон сууцны корпораци” ААТҮГ 1,149.9 сая төгрөгийг, “Ундарга-Алтай” ОНӨААТҮГ 17.0 сая төгрөгийг, “Солонго Дулааны станц” ААТҮГ 35.4 сая төгрөгийг тус тус төлж барагдуулсан.

График 1: Нийт өр төлбөр /байгууллагын төрлөөр/



Байгууллагын төрлөөр ангилж харвал нийт өр төлбөрийн 90 хувийг ОНӨААТҮГ-уудын өглөг, 8 хувийг төсөл сангуудын өглөг, үлдсэн 2 хувийг төсөвт байгууллага, төрийн сангийн өглөг эзэлж байна.

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн

нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт: Өмнөх оны аудитаар нийт 34.3 сая төгрөгийн зөрчил илэрч аудитын явцад 17.5 сая төгрөгийн алдааг залруулж байсан бол тайлант онд 662.7 сая төгрөгийн зөрчил илэрч, аудитын явцад 460.2 сая төгрөгийн алдааг залуулж зөрчил 134 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Залруулагдаагүй дараах зөрчлүүд байна.

Тухайлбал: Өмнөх жилийн өглөгийг барагдуулаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй – 5 байгууллага байна. /хавсралт № 9-д дэлгэрэнгүй харуулав/

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 143,923.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 168,986.0 сая төгрөг болж, 25,062.8 сая төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай байна.

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн шугам сүлжээний ажлыг 4,253.2 сая төгрөгөөр “Солонго Дулааны станц” ААТҮГ-т бүртгэсэн.
- “Ундарга Алтай” ОНӨААТҮГ-ын 295.0 сая төгрөгөөр өссөн нь бохир усны шугам, худгийн таг зэрэг хөрөнгө оруулалтын ажлыг шинээр бүртгэсэн.

Хүснэгт № 8. Засгийн газрын хувь оролцоо

/сая. төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/
Засгийн газрын сан	55,345.25	59,895.59	4,550.33
Хуримтлагдсан үр дүн	47,921.38	68,468.09	20,546.71
Өмнөх үеийн үр дүн	32,003.34	47,955.49	15,952.15
Тайлант оны үр дүн	15,918.04	20,512.60	4,594.56
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	40,656.54	40,622.38	(34.17)
Дүн	143,923.17	168,986.05	25,062.88

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх үеийн үр дүн 15,952.1 сая төгрөгөөр өссөн нь Шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болсон авлагыг өмнөх оны үр дүнд бичилт хийсэнтэй холбоотой байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 34.1 сая төгрөгөөр буурсан нь “0” үлдэгдэлтэй хөрөнгийг шийдвэр гарган данснаас хассанаар дахин үнэлгээний нэмэгдэл данс буурсан байна.

Аудитын илрүүлэлт: Өмнөх оны аудитаар засгийн газрын хувь оролцоо данстай холбоотой зөрчил илрээгүй, тайлант онд 70.9 сая төгрөгийн зөрчил илэрч залруулсан. /2 байгууллага/

3.5.8 Орлогын данс

Тайлант онд аймгийн төсвийн татварын орлого 8,372.2 сая төгрөг, татварын бус орлого 88,739.3 сая төгрөг, тусламж санхүүжилтийн орлого 5,821.0 сая төгрөг нийт 102,932.5 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого, 39.9 сая төгрөгийн үйл ажиллагааны бус орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

Өмнөх оноос нийт орлого 12,684.6 сая төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай байна.

- Татварын орлогын төлөвлөгөө 1,461.5 сая төгрөгөөр давж биелсэн
- Улс орон нутгийн төсвөөс олгох шилжүүлэг өмнөх оноос 11,282.2 сая төгрөгөөр нэмэгдсэн
- Хөрөнгө оруулалтын ажлууд хийгдсэн, Ковид-19 цар тахалтай холбоотой хандиваар үнэ төлбөргүй орлого 4,892.3 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй
- Төсөвт байгууллагын өөрийн орлого 4,622.0 сая төгрөгөөр нэмэгдсэн
- “Ардын дуу бүжгийн Алтай” чуулга нь хөрөнгө борлуулсны авлага үүсгэн, 30.9 сая төгрөгийн орлого нэмж бүртгэсэн, “Алтай ОСК” ААТҮГ-ын 9.0 сая төгрөгийн автомашины граш борлуулсны орлогын үнийн зөрүүг бүртгэлд тусгасан.

Тусламж санхүүжилтийн орлого 4,220.9 сая төгрөгөөр буурсан нь ОНХС-гийн санхүүжилт буурсантай холбоотой байна.

Хүснэгт №9 Үр дүнгийн орлого

/сая.төгрөг/

Код	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өсөлт+, бууралт -
11	Татварын орлого	7,628.22	8,372.18	743.96
12	Татварын бус орлого	72,617.56	88,739.26	16,121.7
13	Тусламж, санхүүжилтийн орлого	10,041.94	5,821.03	(4,220.9)
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	90,287.73	102,932.46	12,644.73
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		39.9	39.9
	НИЙТ ОРЛОГЫН ДҮН	90,287.73	102,972.36	12,684.63

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Татварын бус орлогын 68.6 хувь буюу 60,875.4 сая төгрөгийг улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээр, 0.03 хувь буюу 33.3 сая төгрөгийг тусламжаар, 0.03 хувь буюу 29.78 сая төгрөгийг тусламжийн орлогоор, 31.3 хувь буюу 27,800.6 сая төгрөгийг нийтлэг бус татварын орлогоор /хүү, торгууль, төсөвт байгууллагын өөрийн орлого, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, бусад орлого, түрээсийн орлого, ОНӨААТҮГ-ын борлуулалтын орлого/ тус тус бүрдүүлсэн байна.

Тусламж санхүүжилтийн орлогын 43 хувь буюу 2,507.8 сая төгрөгийг улсын төсвийн санхүүжилтээр, 48.7 хувь буюу 2,838.6 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтээр, 3 хувь буюу 218.1 сая төгрөгийг орон нутгийн санхүүжилтээр, 4 хувь буюу 256.4 сая төгрөгийг нийгмийн даатгалын төсвийн санхүүжилтээр тус тус бүрдүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт: Өмнөх оны аудитаар орлого данстай холбоотой зөрчил илрээгүй, тайлант онд 502.9 сая төгрөгийн зөрчил илэрч, 159.4 сая төгрөгийг залруулсан. Залруулагдаагүй дараах зөрчлүүд байна. /хавсралт № 9-д дэлгэрэнгүй харуулав/

- Туслах үйл ажиллагааны орлого, хандивын орлогыг зөвшөөрөлгүй зарцуулсан 17.3 сая төгрөг-4 байгууллага
- Борлуулалтын орлогыг илүү дутуу тайлагнасан 6.2 сая төгрөг-1 байгууллага
- Түрээсийн орлогыг дутуу төвлөрүүлсэн 0.6 сая төгрөг-2 байгууллага
- Хандив тусламжийн орлогыг тайлагнаагүй 7.6 сая төгрөг-5 байгууллага
- НӨАТ-ын тайлангийн борлуулалтын орлого зөрүүтэй 52.5 сая төгрөг
- Тайлант онд байгууллага болон сангуудад төвлөрвөл зохих орлогыг бүрэн төлөвлөөгүй 127.5 сая төгрөг-1 сан, 4 ААТҮГ гэх мэт

3.5.9 Зардлын данс

Тайлант онд 73,145.2 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал, 9,314.5 сая төгрөгийн үйл ажиллагааны бус нийт 82,459.7 сая төгрөгийн зардал хүлээн зөвшөөрч бүртгэсэн. Нийт зардал өмнөх оноос 9,966.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төрийн албан хаагчдын цалингийн сүлжээ шатлал нэмэгдсэнээр цалингийн зардал өссөн, мөн бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт № 10. Үр дүнгийн зардал

/сая. төгрөг/

Код	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	63,178.73	73,145.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	63,178.73	73,145.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	60,836.80	68,961.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	32,787.00	38,541.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,135.78	4,789.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,755.33	5,741.74
2104	Хангамж, бараа материалын зардал	1,966.61	1,972.17
2105	Нормативт зардал	1,959.94	2,201.98
2107	Томилолт, зочны зардал	518.23	181.29
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,591.30	6,924.21
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,250.23	8,161.75
212	ТАТААС	19.99	16.35
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	19.99	16.35
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	19.99	16.35

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,321.93	4,167.74
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	11,190.96	9,314.53
	НИЙТ ЗАРДЛЫН ДҮН	74,369.69	82,459.76

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт зардлын 83.6 хувь буюу 68,961.1 сая төгрөгийг бараа үйлчилгээний зардал, 5 хувь буюу 4,184.0 сая төгрөгийг урсгал шилжүүлэг, татаас, 11.2 хувь буюу 9,314.5 сая төгрөгийг үйл ажиллагааны бус зардал тус тус эзэлж байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Аймгийн ИТХ-ын 2020 оны 09 дүгээр сарын “Аймгийн 2020 оны төсөв тодотгон батлах тухай” 08 дугаар тогтоолд зааснаар аймгийн төсвийн татварын орлогыг 5,160.9 сая төгрөгөөр, татварын бус орлогыг 795.3 сая төгрөгөөр нийт 5,956.2 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 6,121.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 114 хувиар биелүүлсэн байна.

Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг үзэхэд газрын төлбөрийг 58,606.0 сая төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн албан татварыг 43,171.8 сая төгрөгөөр нийт 101,778.8 сая төгрөгөөр тасарсан. Аудитаар татварын бааз суурийг хамруулж үзээгүй тул орлого тасарсан үндэслэлийг тодорхойлох боломжгүй байлаа.

График 2: Сумдын татварын орлого /хувиар/



Татварын орлогын 82 хувь буюу 6,121.8 сая төгрөгийг аймгийн төсвийн орлого, 18 хувь буюу 2,250.4 сая төгрөгийг сумдын татварын орлогууд тус тус эзэлж байна. Үүнээс: Алтай, Бугат, Баян-Уул сумууд бусад сумтай харьцуулахад өндөр татварын орлого төвлөрүүлсэн байна.

Эх сурвалж: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн төлөвлөлт

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төслийг 2020 онд 68,314.6 сая төгрөгөөр төлөвлөж хянуулсан ба ИТХ-ын тогтоолоор 72,832.3 сая төгрөгийг 2020 оны төсвийн жилд зарцуулахаар баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Аймгийн ИТХ-ын 2020 оны 9 сарын 28-ны өдрийн 08 дугаар тогтоолоор төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 19 хөтөлбөрт зориулан 72,832.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 62,927.9 сая төгрөгийг урсгал зардалд, 8,363.2 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 1,541.1 сая төгрөгийг эргэж төлөгдөх цэвэр зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 38,591.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 31,684.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 320.5 сая төгрөгийг нийгмийн даатгалын сангаас, 2,235.6 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 1,068.8 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 36,190.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 29,922.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 180.7 сая төгрөгийг нийгмийн даатгалын сангаас, 1,539.8 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос нийт 67,834.2 сая төгрөгийн санхүүжилт авч 93 хувийн гүйцэтгэлтэй байна. Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 695.8 сая төгрөгөөр тасарсан нь төсөл сангуудын эх үүсвэр бүрдээгүйгээс шалтгаалжээ.

Аймгийн төсвийн нийт зарлагыг 72,832.3 сая төгрөгөөр баталсан бөгөөд гүйцэтгэлээр 64,822.1 сая төгрөгийн зардал гарсан буюу 89 хувийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлангийн батлагдсан төсвийн гүйцэтгэлийг Сангийн сайдын 2018 оны “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” 07 дугаар тушаалын дагуу эдийн засгийн ангиллаар, бүлгийн дүнгээр авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт № 11: Орон нутгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайлангийн 2020 оны төсвийн гүйцэтгэл /сая.төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны		Зөрүү	Нийт зардалд эзлэх хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	62,087.3	72,832.3	64,822.1	8,010.2	89%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	52,661.1	62,927.9	58,878.2	4,049.7	94%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	51,497.6	61,349.9	57,464.2	3,885.7	94%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	32,392.3	39,656.4	38,174.3	1,482.1	96%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,074.1	5,082.7	4,799.9	282.9	94%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,475.1	6,550.8	6,027.0	523.7	92%
2104	Хангамж, бараа материалын зардал	1,494.8	1,648.4	1,575.1	73.3	96%
2105	Нормативт зардал	1,970.8	2,500.8	1,680.6	820.2	67%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,769.3	1,229.0	1,137.5	91.5	93%
2107	Томилонт, зочны зардал	455.6	220.8	149.2	71.6	68%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,475.7	2,898.9	2,429.3	469.5	84%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,390.0	1,562.1	1,491.2	70.9	95%
212	ТАТААС	20.0	23.0	23.0	-	100%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,143.5	1,555.0	1,391.1	164.0	89%
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	286.9	331.6	319.3	12.3	96%
2132	Бусад урсгал шилжүүлэг	856.5	1,223.4	1,071.8	151.7	88%
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,539.7	8,363.2	5,201.5	3,161.7	62%
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	886.5	1,541.1	742.4	798.8	48%

Төсвийн зардлыг бүлгийн дүнгээр хэтрүүлэн зарцуулаагүй байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын илрүүлэлт:

- Өмнөх оны аудитаар төсвийн гүйцэтгэлийн данстай холбоотой зөрчил илрээгүй, тайлант онд 237.3 сая төгрөгийн зөрчил илэрч, 237.0 сая төгрөгийг залруулсан. Залруулагдаагүй дараах зөрчлүүд байна. Төсвийн хэлбэлзэл зөрүүтэй 0.3 сая төгрөг – 1 байгууллага
- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар 1,591.6 сая төгрөгийн зөрчил илэрч, 169.7 сая төгрөгийг залруулсан. Залруулагдаагүй дараах зөрчлүүд байна. /хавсралт № 10-д дэлгэрэнгүй харуулав/
 - Нэгж байгууллагын татварын тодорхойлолтод заасан өглөг авлага, санхүүгийн тайлангаас зөрүүтэй 1,333.3 сая төгрөг
 - Орон нутгийн орлогын төлөвлөгөө тасарсан боловч бааз суурийг тооцоолоогүй 60.4 сая төгрөг
 - Арилжааны банкинд төсвийн байгууллагын данс үлдэгдэлтэй 2.4 сая төгрөг
 - Санхүүжилт илүү, дутуу олгосон 24.4 сая төгрөг
 - Түрээсийн орлогыг төвлөрүүлээгүй 1.3 сая төгрөг -2 байгууллага

- Төсвийн хэлбэлзэл зөрүүтэй 0.3 сая төгрөг – 1 байгууллага

Нэмэлт санхүүжилт


Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

- ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөнөөс 947.0 сая төгрөг
- Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөнөөс 1,502.8 сая төгрөг
- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 371.1 сая төгрөгийн нийт 2,820.9 сая төгрөгийг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлсний зардалд 100.6 сая төгрөг, тогтмол зардалд 3.6 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 151.5 сая төгрөг, норматив зардалд 103.7 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 193.8 сая төгрөг, дотоод албан томилолтын зардалд 30.2 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 1,645.5 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 229.9 сая төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжид 705.6 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардалд 34.7 сая төгрөг, хөрөнгийн зардалд 158.0 сая төгрөг нийт 3,357.2 сая төгрөгийг зарцуулж, 230.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

График:3: Нэмэлт санхүүжилтийн орлого, зарцуулалтыг салбараар харуулбал:

/сая.төгрөг/



Нэмэлт санхүүжилтийн орлогын 5.9 хувь буюу 212.6 сая төгрөгийг эрүүл мэндийн салбарт, 25.2 хувь буюу 906.5 сая төгрөгийг боловсролын салбарт, 53.7 хувь буюу 1,929.4 сая төгрөгийг орон нутгийн ЗДТГ, ИТХ-д, 15 хувь буюу 538.7 сая төгрөгийг бусад байгууллагуудад олгосон байна.

Тайлант онд өндөр нэмэлт санхүүжилт авсан ЗДТГ-т ХХААГ-аас Оготно устгалд 104.2 сая төгрөгийг 14 сумын ЗДТГ, царцаа устгалд 85.7 сая төгрөгийг 2 сумын ЗДТГ, НҮБ-ын хүүхдийн сангаас 898.7 сая төгрөг, бусад эх үүсвэрээс хандиваар 107.6 сая төгрөг, баяр наадмын зардалд 51.9 сая төгрөг, БХЯ-аас 4 сая, БОАЖЯ-аас 40.0 сая төгрөг, Үндэсний архивын газраас 27.3 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Нэмэлт санхүүжилтийн дансаар олгож байгаа санхүүжилтийн зарцуулалт, үр дүнг тооцохгүй байгаа нь төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэлийг бий болгож байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

А. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд: Төсвийн ерөнхийлөн захирагчийн Шилэн дансны мэдээллийг тулган баталгаажуулахад 150 мэдээлэл оруулахаас 42 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн шийдвэрүүдийг 11 сард буюу хугацаа хоцорч оруулсан, худалдан авах ажиллагааны тайланг дутуу мэдээлсэн, Засаг даргын 12 “Б” захирамжийг

мэдээлээгүй, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнг мэдээлээгүй, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг мэдээлээгүй.

В. Харьяа нэгж байгууллагын тухайд: Аудитаар Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяаны 198 байгууллагын шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулсан байдлыг үзлээ. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг салбараар нь ангилбал боловсролын салбарын байгууллагуудын хэрэгжилт 89 хувьтай, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын хэрэгжилт 80 хувьтай, сумдын ЗДТГ, ИТХ, ТТЗ-ийн хэрэгжилт 87 хувьтай байгаа бол бусад байгууллагуудын хэрэгжилт 81 хувьтай байна. Нэгж байгууллагын хувьд 50 хувиас доош мэдээлэл оруулсан дараах байгууллагууд байна.

- Эрдэнэ сумын Ерөнхий боловсролын сургууль 34 хувийг,
- Дэлгэр сумын Гуулин тосгоны сургууль 52 хувийг,
- Гэр, бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар 59 хувийг мэдээлсэн
- “Алтай Орон сууцны корпораци” ААТҮГ нь мэдээлэл оруулаагүй буюу хуулийг хангалтгүй хэрэгжүүлж байна.

Байгууллагууд нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл, худалдан авалтын аудитын тайлан, дүгнэлт, ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдэл болон бусад хяналт шалгалтын дүнг мэдээлдэггүй нийтлэг зөрчил байна.

Түүвэрт хамрагдсан аймгийн ОНХС-гийн шилэн дансанд гарсан зөрчлийг тайлангийн 3.9-д харуулав.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

А. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд :

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид 1,005.2 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 271.8 сая төгрөгийн асуудлыг хуулийн байгууллагад хүргүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилтийг хянахад орон нутгийн орлого, сум хөгжүүлэх сангийн орлогын төлөвлөгөө тасарсан, өр авлага үүсгэсэн зөрчлүүдийг давтан гаргасан байна. Мөн хуулийн байгууллагад шилжүүлсэн 271.8 сая төгрөгийн асуудлыг эцэслэн шийдвэрлээгүй байна.

Хүснэгт №12: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шийдвэрийн төлбөрийн хэрэгжилт /сая.төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	2	197.2			2	197.2	0
Албан шаардлага	4	1,005.2	4	1,005.2	0	0	100%
Хуулийн байгууллагад	1	271.8	1	271.8	1	271.8	0
Зөвлөмж	1		1				0
Нийт	5	1,027.0	5	1,027.0	1	271.8	

В. Харьяа нэгж байгууллагын тухайд:

Төсвийн ерөнхийлөн захирагчдад нэгтгэгддэг нэгж байгууллагуудын өмнөх онуудад хийсэн санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитын шийдвэрийн үлдэгдэл төлбөрийн акт 2,173.3 сая төгрөг, албан шаардлага 2,097.2 сая төгрөг байна. /хавсралт №11-ээс дэлгэрэнгүйг харуулав/

Төсөвт байгууллагууд өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилтийг албан бичгээр ирүүлсэн бөгөөд илэрсэн зөрчлийг арилгасан эсэхийг тайлант онд давтан хянахад амралтын цалинг үндсэн цалинтай давхардуулан олгосон, цалингийн нэмэгдлийг илүү дутуу олгодог, урьдчилгаа аваад төлөөгүй, хөрөнгийн тооллогыг зөрүүтэй хийдэг, нярвын тайлан НББ-ээс зөрүүтэй, төсөл сангаас олгосон зээлийн эргэн төлөлт хангалтгүй, авлага өглөгийг барагдуулаагүй зэрэг зөрчил давтан гарчээ. Цаашид дотоод хяналт, хариуцлагыг сайжруулан зөрчлийг давтан гаргахгүй байх нь зүйтэй.

Өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг тайлант онд давтан гаргасан нь хяналт шалгалтын үр өгөөжийг бууруулж төсвийн захирагчид төсөв бүрдүүлж, захиран зарцуулахдаа зөрчлийг байж болох асуудал мэт үзэн, ажилдаа хариуцлагагүй хандах үр дагаврыг бий болгосон байна.

Дараа жилийн аудитаар зөрчил давтагдан гарсан тохиолдолд албан тушаалтанд хариуцлага тооцох үндэслэл болно гэдгийг анхаарч төсвийг зүй зохистой удирдан ажиллах шаардлагатай.

Өмнөх шийдвэрийг хэрэгжүүлээгүй албан тушаалтнуудад хариуцлага тооцох албан шаардлагыг хүргүүлсэн.

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төсөвт байгууллага 153, төсөл сан 58, төрийн сангийн 20, ОНӨҮГ 11 нийт 242 санхүүгийн тайланг нэгтгэсэн байна. Аудитаар 162 санхүүгийн тайланд бие даасан дүгнэлт гаргасан, 1 санхүүгийн тайлан аудитад хамрагдаагүй, сумдын ИТХ, ОНХС, БХНСС ИТХ, Соёлын төв, 3 бага сургууль, Шатрын сургууль, Химийн лицей сургууль, Ахмадын хороо зэрэг нийт 79 байгууллагыг аудитын түүвэрт хамруулсан.

Дээрх байгууллагуудаас “Орон сууцны алба” ОНӨААТҮГ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дахь заалтад заасан хугацаанд тайлангаа ирүүлээгүйн улмаас санхүүгийн тайланд аудит хийгдээгүй.

Төрийн аудитын газар нь үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийж байгаатай холбогдуулан хөрөнгө оруулалтын тайланг аудитад хамруулж үзээгүй болно.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас “Зөрчилгүй” 118, “Хязгаарлалттай” 41, “Сөрөг” 3 /Есөнбулаг сумын 4 дүгээр сургууль, Баян-Уул сумын ЕБС, “Дарив Эрчим хүч” ОНӨААТҮГ/ дүгнэлт өгсөн байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг нэгж байгууллага, санд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 16,421.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 6,248.0 сая төгрөгийн алдааг залруулж, 829.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5,237.9 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгах албан шаардлага, алдаа, зөрчил гаргасан 43 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж, 4,105.0 сая төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өглөө.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийгдээгүй, тайланд 86,406.9 сая төгрөгөөр устгах бичилт хийсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн албан шаардлага

1. СХС-гийн хөрөнгөөр сумдад 2015 онд хийгдсэн 138.1 сая төгрөгийн оёдлын болон ахуйн үйлчилгээний тоног төхөөрөмж ашиглагдахгүй 6 жил болсон ба 36.6 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг гэрээ, төлбөргүйгээр ашиглуулж байгаа нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1-д "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, хэмжилт батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

2. Сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн 135.8 сая төгрөгийн том оврын ковш, олон үйлдэлт тракторууд ашиглагдахгүй /эвдэрсэн/, 506.0 сая төгрөгийн хөрөнгийг хувь хүмүүст харилцан адилгүй заалттай гэрээ /төлбөртэй, төлбөргүй/ байгуулан ашиглуулж байгаа, иргэд олон нийт хөрөнгийн үр өгөөжийг тэгш хүртэхгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1-д "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, хэмжилт батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

3. Аймгийн ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй 92.0 сая төгрөгийн өртөг бүхий орон сууц нь "Хүрийн овоо" ХХК-ийн нэр дээр бүртгэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1-д "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, хэмжилт батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

4. Орон нутгийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ биелүүлсэн боловч газрын төлбөр 58.6 сая төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 43.17 сая төгрөгөөр нийт 101.7 сая төгрөгөөр тасарсан. /Аудитаар татварын бааз суурийг хамруулж үзээгүй тул орлого тасарсан үндэслэлийг тодорхойлох боломжгүй байсан болно./ Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.2.3-т "Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.10-т "Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, хэмжилт батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

5. Тайлант онд удирдлагын буруутай шийдвэрээс болж ажлаас халагдсан ажилтанд 56.6 сая төгрөгийн нөхөн төлбөрийг төсвөөс олгосон, өмнөх оны Шүүхийн шийдвэрийн авлага 222.8 сая төгрөгийг барагдуулахаар ямар нэгэн арга хэмжээ авч ажиллаагүй байгаа нь Захиргааны ерөнхий хуулийн 103 зүйлийн 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ", 103.2-т "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна", Хөдөлмөрийн тухай

хуулийн 132 дугаар зүйлийн 132.1-т "Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцдаа өөрийн буруугаас байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан ажилтанд сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, хэмжилт батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

6. Шилэн дансны цахим хуудсанд 150 мэдээлэл оруулахаас 42 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн шийдвэрүүдийг 11 сард буюу хугацаа хоцроож оруулсан, худалдан авах ажиллагааны тайланг дутуу мэдээлсэн, Засаг даргын 12 "Б" захирамжийг мэдээлээгүй, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны "Журам шинэчлэн батлах тухай" 29 дүгээр тогтоолыг хэрэгжүүлээгүй, эрх ба үүрэг, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

7. Харьяа байгууллагууд нь өмнөх аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй байгаа нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

8. Тайлант онд Чандмань сумын ОНХС-гаас худалдан авсан 15.5 сая төгрөгийн хөрөнгийг /трактор/ НББ-д давхар бүртгэсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-т "Төрийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан журмаар үнэлж бүртгэнэ" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

9. Халиун сумын СХС-гийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тоног төхөөрөмжөөс 12.8 сая төгрөгийн хөрөнгө дутагдсан бөгөөд 6 иргэнд эзэмшүүлсэн гэх боловч гэрээгүй, төлбөр авахгүйгээр 5 жил ашиглуулсан нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1-д " өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

10. Төсөвт байгууллагууд нь он дамжсан олон жилийн насжилттай, төлөгдөхгүй байгаа 248.4 сая төгрөгийн, эзэн холбогдогч тодорхойгүй 5.0 сая төгрөгийн авлагын үлдэгдэл байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 37 дугаар зүйлийн 37.1.1-д "Төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавих" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

Аудитын түүвэрт хамрагдсан нэгжид хүргүүлсэн албан шаардлага:

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан:

1. ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудаас 48.0 сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25.1-т "Төрийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан журмаар үнэлж бүртгэнэ", Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "ОНХС-гийн үйл ажиллагааны журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.12-т "ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна" гэж заасныг зөрчсөн, эрх ба үүрэг, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

2. "Соёл амралтын хүрээлэнд морин тойруулга, алсыг харагч суурилуулах" ажлын гэрээний хугацаа дууссан бөгөөд нэмэлт гэрээ хийгээгүй байхад одоог хүртэл огт ажил хийгдээгүй байгаа нь Гүйцэтгэгчтэй байгуулсан "Соёл амралтын хүрээлэнд морин тойруулга, алсыг харагч суурилуулах" ажлын ГААОНҮГ/202001011 дугаартай гэрээний заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

3. "Соёл амралтын хүрээлэнд морин тойруулга, алсыг харагч суурилуулах" ажлын гэрээний дагуу 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар 33.6 сая төгрөгийн алдангийг тооцож төлүүлээгүй байгаа нь Гүйцэтгэгчтэй байгуулсан "Соёл амралтын хүрээлэнд морин тойруулга, алсыг харагч суурилуулах" ажлын ГААОНҮГ/202001011 дугаартай гэрээний 3.1.20 дахь заалт /Гэрээт ажлыг батлагдсан зураг төсвийн дагуу гүйцэтгэх ба гэрээт хугацаандаа ашиглалтад оруулаагүй бол гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний үнийн 0.05 хувиар алданги төлнө. Алданги төлснөөр гүйцэтгэх үүргээс чөлөөлөгдөхгүй/-тай нийцэхгүй, эрх ба үүрэг, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

4. "Соёл амралтын хүрээлэнд морин тойруулга, алсыг харагч суурилуулах" ажлын гэрээг гүйцэтгэгчийн санал болгосон үнээс 1.46 сая төгрөгөөр илүү байгуулсан нь Тендерийн бичиг баримт, үнийн санал, Үнэлгээний хорооны "Гэрээ байгуулах эрх олгох тухай санал"-ыг зөрчсөн, эрх ба үүрэг, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Төвлөрүүлэн захирагчийн төсөвт төвлөрүүлэх орлогын бааз суурийн үнэн зөв байдлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ. Мөн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг үр ашигтай, үр нөлөөтэй зарцуулах тал дээр анхаарах хэрэгтэй байна.

- Сумдын ЗДТГ-уудаас 7 сумын ЗДТГ өөрийн буудалтай бөгөөд Төгрөг, Баян-Уул, Тайшир сумын ЗДТГ хоногийн төлбөр авдаг, Хөхморьт, Бугат, Эрдэнэ сумын ЗДТГ хоногийн төлбөр авдаггүй, Шарга сумын ЗДТГ түрээсийн гэрээгээр ашиглуулж байна.

- Монгол Улсын Хөгжлийн банк, аймгийн Засаг дарга нарын хооронд хийсэн 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 2168 дугаар "Үл хөдлөх хөрөнгө зээлээр худалдах, худалдан авах гэрээ"-ний дагуу "Алтай ОСК" ААТҮГ нь Хөгжлийн банканд өссөн дүнгээр 2021 онд 1,136.4 сая төгрөгийн, 2022 онд 2,336.9 сая төгрөгийн, 2023 онд 3,437.2 сая төгрөгийн, 2024 онд 4,456.3 сая төгрөгийг төлөхөөр байгаа боловч эх үүсвэр дутагдахаар тооцоотой байна.
- "Орон сууны алба" ААТҮГ нь тайлангаа нэгтгэсэн тайланд нэгтгүүлсэн боловч, тус байгууллагыг татан буулгах эцсийн шийдвэр гараагүй байхад хөрөнгийг орон нутгийн өмчөөс хассан байна.
- Хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудад и-баримтгүй гүйлгээ хийсэн байна.

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данс, ОНХС-тай холбоотой асуудал

1.Илрүүлэлт: Төсөвт байгууллагуудын 2020 оны халаалтын тооцоог тулган баталгаажуулахад 136.5 сая төгрөгийг дулаан үйлдвэрлэгч компаниудад илүү төлсөн байна.

Эрсдэл: Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах

Зөрчигдсөн хуулийн заалт: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"-ыг, Говь Алтай аймгийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/206 дугаар "Халаалтыг зогсоох тухай" захирамжийг зөрчсөн.

2.Илрүүлэлт: ОНХС-гаас 2,939.3 сая төгрөгийн гүйлгээг и-баримтгүйгээр хийсэн байна.

Эрсдэл: Татварын орлогыг нуун дарагдуулах

Зөрчигдсөн хуулийн заалт: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралт "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ыг 6.5-д "Төлбөрийн баримт НХМаягт ТМ-5 Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ"-ыг зөрчсөн.

Санхүү төрийн сангийн хэлтэст:

Өгсөн зөвлөмж:

1. Төсвийн ерөнхийлөн захирагчаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг тооцох
2. НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан и-баримтгүй гүйлгээ хийхгүй байх

Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

2. Өглөг, авлага, анхан шатны баримттай холбоотой асуудал

1.Илрүүлэлт: Төсөвт байгууллагуудын 2020 оны жилийн эцсийн татварын тодорхойлолтоор 285.4 сая төгрөгийн дутуу, 994.1 сая төгрөгийн илүү төлөлт татварын цахим системд бүртгэлтэй.

Эрсдэл: Хэрэглэгч буруу мэдээллээр хангах

Зөрчигдсөн хуулийн заалт: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" заалтыг зөрчсөн.

2.Илрүүлэлт: ОНХС-гаас 2,939.3 сая төгрөгийн гүйлгээг и баримтгүйгээр хийсэн байна.

Эрсдэл: Татварын орлогыг нуун дарагдуулах

Зөрчигдсэн хуулийн заалт: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралт "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ыг 6.5-д "Төлбөрийн баримт НХМаягт ТМ-5 Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ"-ыг зөрчсөн.

Татварын хэлтэст:

Өгсөн зөвлөмж:

1. Татварын цахим системд бүртгэгдсэн илүү, дутуу төлөлтийг тооцоо нийлэн баталгаажуулж шийдвэрлэх
2. Дээрх ААН-ын үйл ажиллагаанд хяналт хийх

Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

3. Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт, ОНХС-тай холбоотой асуудал

1.Илрүүлэлт: Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайланд 7 орон нутгийн өмчит ААТҮГ-ууд нь 2020 онд орлогыг 199.4 сая төгрөгөөр дутуу, зардлыг 53.2 сая төгрөгөөр хэтрүүлэн, алдагдал нийт дүнгээрээ 252.6 сая төгрөгөөр өссөн байна.

Эрсдэл: Хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах

Зөрчигдсэн хуулийн заалт: Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.2.3-д "Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.10-т "Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг / цаашид "захирал" гэх/ томилохдоо гэрээ байгуулна. Гэрээнд дараах нөхцөлийг тусгана:1/ энэ хуульд заасан эрх, үүрэг; 2/ эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшин; 3/ техник, технологийг шинэчлэх даалгавар; 5/ менежментийн бодлого; 6/ захирлаас болон үүргээ биелүүлэх талаар төрөөс хүлээх үүрэг; 10/ энэ хуульд заасан эд хөрөнгийн хариуцлага; 11/ гэрээний үүргийн биелэлтийг дүгнэх журам, хугацааг тусгана./ 19.2 дахь заалт/Захирал гэрээгээр тохиролцсон үүргээ биелүүлээгүй нь хүндэтгэн үзэх бодит шалтгаангүй бол түүнийг ажлаас халах үндэслэл болно/ 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалт /Үйлдвэрийн газрын захирал үйлдвэрийн

газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах/-ыг зөрчсөн.

2.Илрүүлэлт: Сумдын ЗДТГ дээр бүртгэлтэй малыг тулган баталгаажуулахад 322.2 сая төгрөгийн малжуулалтын гэрээний хугацаа дууссан, сунгагдаагүй, 42.6 сая төгрөгийн мал өгсөн боловч гэрээ байгуулаагүй, 20.0 сая төгрөгийн мал бодитоор байхгүй, гэрээний хугацаа дууссан байхад 15.3 сая төгрөгийн малын үнийг мөнгөөр төлөөгүй, НББ-ээс зөрүүтэй 26.8 сая төгрөгийн мал байна.

Эрсдэл: Хөрөнгө дутагдах, эзэнгүйдэх

Зөрчигдсэн хуулийн заалт: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1.аж ахуйн бүх ажил, гүйлгээ; 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага; 14.4.3.бүх өр төлбөр; 14.4.4.аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр; 14.4.5.бүх орлого; 14.4.6.бүх зардал; 14.4.7.нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлс/, 20.2.3-т /холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах"-ыг зөрчсөн.

3.Илрүүлэлт: Хэрэгжсэн төсөл арга хэмжээнээс 262.9 сая төгрөгийн 1 ажилд захиалагчийн хяналт тавьж ажиллаагүй

Эрсдэл: Хөрөнгө оруулалтын ажил зураг төсөв, ТЭЗҮ-ийн дагуу хийгдэхгүй, чанаргүй хөрөнгө оруулалт хийгдэх.

Зөрчигдсэн хуулийн заалт: Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалын хавсралтын 9.4-т "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд", Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны "Дүрэм батлах тухай" 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дотоод аудитын дүрэм" болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина" гэсэн заалтыг зөрчсөн.

Аймгийн Засаг даргад:

Өгсөн зөвлөмж:

1. ОНӨААТҮГ-уудын үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэн, үр ашгийг дээшлүүлэх
2. Малжуулах ажлын үр дүнг тооцож ажиллах
3. Захиалагчийн хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлж хөрөнгө оруулалтын үр дүнг тооцох

Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

4. Орон нутгийн хөгжлийн сангийн асуудал

1.Илрүүлэлт: Иргэдээс санал аваагүй, эрэмбэлэгдээгүй 645.0 сая төгрөгийн 20 төсөл арга хэмжээг аймгийн ИТХ-аар баталсан.

Эрсдэл: Иргэд олон нийтэд шаардлагатай хөрөнгө оруулалт хийгдэхгүй байх.

Зөрчигдсөн хуулийн заалт: Төсвийн тухай хуулийн 60.3.6.орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ., Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалын хавсралт "ОНХС-ийн үйл ажиллагааны журам-ын 3.1.2-т "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх", 4.2.1.Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-т заасан зүйлсийг зөрчсөн.

2.Илрүүлэлт: ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл, төсвийн тооцоолол, төсөвт нөлөөлөх байдлын үнэлгээ хийж, хэрхэн шийдвэрлэх тухай санал тусгагдаагүй 1,961.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 29 ажлыг ИТХ-аар баталсан.

Эрсдэл: Хөрөнгө оруулалтын төсөвт өртөг өсөх, он дамжих, иргэд олон нийтэд үр өгөөжөө өгөхгүй байх

Зөрчигдсөн хуулийн заалт: Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалын хавсралт "ОНХС-ийн үйл ажиллагааны журам-ын 2.7-д "Энэ журмын 2.5 ба 2.6-д заасан ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ бүрийг тухайн шатны ИТХ хэлэлцэн батална", 3.1.3-т "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх", 3.1.7-д "Аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн ажлын хэсэг нь тус сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр санал болгож буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргах", 4.3-т "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний санал нь энэ журмын 3 дугаар бүлэгт заасан нөхцөлийг хангаагүй, мөн 4.2-т заасныг хэрэгжүүлэхээр бол нэгдсэн жагсаалтаас хасах үндэслэл болно"-ыг зөрчсөн.

3.Илрүүлэлт: Хэрэгжсэн төсөл арга хэмжээнээс 2,811.4 сая төгрөгийн 39 ажилд хяналтын хорооны хяналт тавьж ажиллаагүй.

Эрсдэл: Хөрөнгө оруулалтын ажил зураг төсөв, ТЭЗҮ-ийн дагуу хийгдэхгүй, чанаргүй хөрөнгө оруулалт хийгдэх.

Зөрчигдсөн хуулийн заалт: Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалын хавсралтын 9.4-т "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд төв, орон нутгийн хууль, хяналт, дотоод ба хөндлөнгийн аудитын байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд", Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны "Дүрэм батлах тухай" 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дотоод аудитын дүрэм" болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина.

Аймгийн ИТХ-ын даргад:

Өгсөн зөвлөмж:

1. Иргэдээс санал аваагүй, эрэмбэлээгүй, ТЭЗҮ, зураг төсөвгүй, ажлын даалгаваргүй, төсөвт нөлөөлөх ачааллыг тооцоогүй төсөл арга хэмжээг ИТХ-аар батлахгүй байх

2. ИТХ-ын дэргэдэх хяналтын хорооны хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлж, үр дүнг хэлэлцэн, зөрчлийг тухай бүр арилгуулж ажиллах
Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.04.19	Аудитын нэр: Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код: ГАА-2021/1/СТА-ТЕЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Говь-Алтай аймгийн ТЭЗ	сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан					
1	ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудаас 48.0 сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй байна.	48.0	Албан шаардлага өгөх	Аймгийн Засаг дарга	О.Амгаланбаатар
2	"Соёл амралтын хүрээлэнд морин тойруулга, алсыг харагч суурилуулах" ажлын гэрээг гүйцэтгэгчийн санал болгосон үнээс 1.5 сая төгрөгөөр илүү байгуулсан.	1.5	Албан шаардлага өгөх	Аймгийн Засаг дарга	О.Амгаланбаатар
3	"Соёл амралтын хүрээлэнд морин тойруулга, алсыг харагч суурилуулах" ажлын гэрээний дагуу 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар 33.7 сая төгрөгийн алдангийг тооцож төлүүлээгүй байна.	33.7	Албан шаардлага өгөх	Аймгийн Засаг дарга	О.Амгаланбаатар
4	"Соёл амралтын хүрээлэнд морин тойруулга, алсыг харагч суурилуулах" ажлын гэрээний хугацаа дууссан бөгөөд нэмэлт гэрээ хийгээгүй байхад одоог хүртэл газар дээр ажил огт хийгдээгүй байна.	263.0	Албан шаардлага өгөх	Аймгийн Засаг дарга	О.Амгаланбаатар
5	ОНХС-гаас 2,939.3 сая төгрөгийн гүйлгээг и-баримтгүйгээр хийсэн байна.	2,939.3	Зөвлөмж өгөх	Санхүү төрийн сангийн хэлтэс, Аймгийн Татварын хэлтэс,	Х.Баатарзориг, Б.Энхтуяа
6	Хэрэгжсэн төсөл арга хэмжээнээс 2,811.5 сая төгрөгийн 39 ажилд хяналтын хорооны хяналт тавьж ажиллаагүй.	-	Зөвлөмж өгөх	ИТХ-ын дарга	Д.Даваадорж
7	ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл, төсвийн тооцоолол, төсөвт нөлөөлөх байдлын үнэлгээ хийж, хэрхэн шийдвэрлэх тухай санал тусгагдаагүй 1,961.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 29 ажлыг ИТХ-аар баталсан	-	Зөвлөмж өгөх	ИТХ-ын дарга	Д.Даваадорж
8	Хэрэгжсэн төсөл арга хэмжээнээс 263.0 сая төгрөгийн 1 ажилд захиалагчийн хяналт тавьж ажиллаагүй	-	Зөвлөмж өгөх	Аймгийн Засаг дарга	О.Амгаланбаатар
9	Иргэдээс санал аваагүй, эрэмбэлэгдээгүй 645.0 сая төгрөгийн 20 төсөл арга хэмжээг аймгийн ИТХ-аар баталсан.	-	Зөвлөмж өгөх	ИТХ-ын дарга	Д.Даваадорж
Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар					

**Говь-Алтай аймгийн Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

1	Тайлант онд Чандмань сумын ОНХС-гаас худалдан авсан 15.5 сая төгрөгийн хөрөнгийг /трактор/ НББ-д давхар бүртгэсэн байна	15.5	Албан шаардлага өгөх	Санхүү, төрийн сангийн хэлтэс	Х.Баатарзориг
2	Халиун сумын СХС-гийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тоног төхөөрөмжөөс 12.9 сая төгрөгийн хөрөнгө дутагдсан бөгөөд 6 иргэнд эзэмшүүлсэн гэх боловч гэрээгүй, төлбөргүй авахгүйгээр 5 жил ашиглуулсан байна.	12.9	Албан шаардлага өгөх	Аймгийн Засаг дарга	О.Амгаланбаатар
3	Аймгийн ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй 92.0 сая төгрөгийн өртөг бүхий орон сууц нь "Хүрийн овоо" ХХК-ний нэр дээр бүртгэлтэй байна.	92.0	Албан шаардлага өгөх	Аймгийн Засаг дарга	О.Амгаланбаатар
4	Сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн 135.9 сая төгрөгийн том оврын ковш, олон үйлдэлт тракторууд ашиглагдахгүй /эвдэрсэн/, 506.1 сая төгрөгийн хөрөнгийг хувь хүмүүст харилцан адилгүй гэрээ /төлбөртэй, төлбөргүй/ байгуулан ашиглуулж байгаа, иргэд олон нийт хөрөнгийн үр өгөөжийг тэгш хүртэхгүй байна.	506.1	Албан шаардлага өгөх	Аймгийн Засаг дарга	О.Амгаланбаатар
5	Сумдын СХС-гийн хөрөнгөөр 2015 онд хийгдсэн 138.1 сая төгрөгийн оёдлын болон ахуйн үйлчилгээний тоног төхөөрөмж ашиглагдахгүй 6 жил болсон ба 36.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж ашиглагдаж байгаа боловч гэрээгүй, төлбөргүйгээр ашиглуулж байна.	138.1	Албан шаардлага өгөх	Аймгийн Засаг дарга	О.Амгаланбаатар
6	Тайлант онд удирдлагын буруутай шийдвэрээс болж ажлаас халагдсан ажилтанд 56.7 сая төгрөгийн нөхөн төлбөрийг төсвөөс олгосон, өмнөх оны Шүүхийн шийдвэрийн авлага 222.8 сая төгрөгийг барагдуулахаар ямар нэгэн арга хэмжээ авч ажиллаагүй байна.	-	Албан шаардлага өгөх	Аймгийн Засаг дарга	О.Амгаланбаатар
7	Төсөвт байгууллагууд нь он дамжсан олон жилийн насжилттай, төлөгдөхгүй байгаа 248.5 сая төгрөгийн, эзэн холбогдогч тодорхойгүй 5.1 сая төгрөгийн авлагын үлдэгдэл байна.	-	Албан шаардлага өгөх	Санхүү, төрийн сангийн хэлтэс	Х.Баатарзориг
8	Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайланд 7 орон нутгийн өмчит ААТҮГ-ууд нь 2020 онд орлогыг 199.4 сая төгрөгөөр дутуу, зардлыг 53.2 сая төгрөгөөр хэтрүүлэн, алдагдал нийт дүнгээрээ 252.7 сая төгрөгөөр өссөн байна.	-	Зөвлөмж өгөх	Аймгийн Засаг дарга	О.Амгаланбаатар
9	Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг үзэхэд газрын төлбөрийг 58.6 сая төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн албан татварыг 43.2 сая төгрөгөөр нийт 101.8 сая төгрөгөөр тасарсан. Аудитаар татварын бааз суурийг хамруулж үзээгүй тул орлого тасарсан үндэслэлийг тодорхойлох боломжгүй байлаа.	101.8	Албан шаардлага өгөх	Аймгийн Засаг дарга	О.Амгаланбаатар
10	Шилэн дансны цахим хуудсанд 150 мэдээлэл оруулахаас 43 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн шийдвэрүүдийг 11 сард буюу хугацаа хоцорч оруулсан, худалдан авах ажиллагааны тайланг дутуу мэдээлсэн, Засаг даргын 12 Б захирамжийг мэдээлээгүй, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнг мэдээлээгүй, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг мэдээлээгүй.	-	Албан шаардлага өгөх	Аймгийн Засаг дарга	О.Амгаланбаатар

**Говь-Алтай аймгийн Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

11	Төсөвт байгууллагуудын 2020 оны жилийн эцсийн татварын тодорхойлолтоор 285.4 сая төгрөгийн дутуу, 994.1 сая төгрөгийн илүү төлөлт татварын цахим системд бүртгэлтэй.	-	Зөвлөмж өгөх	Татварын хэлтэс	Н.Энхтуяа
12	Төсөвт байгууллагуудын 2020 оны халаалтын тооцоог тулган баталгаажуулахад 136.5 сая төгрөгийг дулаан үйлдвэрлэгч компаниудад илүү төлсөн байна.	136.5	Зөвлөмж өгөх	Аймгийн Засаг дарга	О.Амгаланбаатар
13	ТЕЗ-ийн харьяа байгууллагууд нь аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй байна.	-	Албан шаардлага өгөх	Аймгийн Засаг дарга	О.Амгаланбаатар
14	Сумдын ЗДТГ дээр бүртгэлтэй малыг тулган баталгаажуулахад 322.2 сая төгрөгийн малжуулалтын гэрээний хугацаа дууссан, сунгагдаагүй, 42.6 сая төгрөгийн мал өгсөн боловч гэрээ байгуулаагүй, 20.1 сая төгрөгийн мал бодитоор байхгүй, гэрээний хугацаа дууссан байхад 15.3 сая төгрөгийн малын үнийг мөнгөөр төлөөгүй, НББ-ээс зөрүүтэй 26.9 сая төгрөгийн мал байна	-	Зөвлөмж өгөх	Аймгийн Засаг дарга	О.Амгаланбаатар
	Нийт дүн	4,288.3			